


Олон Улсын Амнести

МОНГОЛ УЛС

ХОРИГДЛУУД ӨЛБӨРЧ ҮХЭЖ  
БАЙНА

1995 оны 4-р сар

Индекс: ASA 30/02/95



Олон улсын Тамгын Газар  
1 Easton Street  
London WC1X 8DJ  
Англи Улс

"Ах маань баахан хулигаан маягийн хүн байлаа. 1978, 79 оны үед анх шоронд орж, түүнээс хойш хоёр гурван жилээр таслуулан тав, зургаан удаа шоронд орсон билээ. Хамгийн сүүлд баригдаад явсан нь 1993 оны наймдугаар сар байв. Архи ууж согтоод нэг нөхрийнхөө гэрээс нэг хивс, бас бус хогшлыг нь хулгайлсан юмсанж. Тэгээд энд, Улаанбаатар дахь Ганц Худагийн шоронд хоригдсон юм.

Арван хоёрдугаар сард "Бие муу. Ирж уулз" гэсэн цахилгаан утас ахаас ирсэн боловч чухам хаанаас явуулсан нь тодорхойгүй байв. Бид Ганц Худагт хүрч очвол ах байсангүй, харин шилжүүлсэн хоригдлуудын нэрсийн жагсаалтаас нэрийг нь олж авлаа. Сарын эхээр ахын хэргийг хянан шийдвэрлээд Улаанбаатараас зуугаад километрийн чанад орших Мааньтын шоронд шилжүүлсэн юм байжээ.

Хоёрдугаар сарын сүүлчээр "Бие дордов. Хурдан ир" гэсэн бас нэг цахилгаан аваад Маантад очиж, ахтай уулзах хоёр хоногийн зөвшөөрөл авч чадав ( Гэрийнхэн нь хоригдолтой уулзан хамт байж болдог уулзалтын тусгай байр шоронд байдаг юм). Ах маань ёстой л яс арьс болоод, хөлөө арайхийн зөөсөөр орж ирлээ. Хичнээн их турж эцсэнээ налад харуулахад биед нь мах өөх ч алга, гар нь чөрийгөөд, харьтаа атгахад гарт нь өлхөн багтаж байв. Амьдаараа араг яс болсон байж билээ...

Бид хоол унд өгсөн боловч ходоод нь ч хүртэл хоол боловсруулах хүчилгүй болсон бололтой. Анхны өдөр идсэн хоол нь тогтохгүй гүйлгээд байв. Маргааш нь идсэн ууснаа цөмийг бөөлжөөд гаргачихав. Орой нь бид эм тариа ирүүлье гэлцээд ахыгаа орхиод явлаа.

Гэтэл арваад хоногийн дараа Ганц Худагаас нэг албаны хүн утасдаж, ахын бие улам дордсон учраас шоронгийн төв эмнэлэгт буцааж шилжүүлсэн гэж хэллээ. Маргааш нь бид тэр эмнэлэгт очив. Эхлээд эмчилж байгаа эмчтэй нь уулзсанд хэрэгтэй бүхий л эмчилгээг хийсэн

*боловч дэндүү оройтсон учраас найдлагагүй болжээ гэв. Тэгээд ах дээрээ орвол сунс нь хэдийн явчихсан, үг дуугарах ч тэнхэлгүй хүн хэвтэж байлаа. Миний бие дэргэд нь сууж, гарыг нь атгаад хамт залбирахдаа миний залбирлыг сонссон гэдгийг мэдсэн юм. Намайг залбирсны дараахан ахын нүдэнд нулимс мэлмэрч харагдсан билээ...*

*Тэр өдөр бид ахыг эмнэлэгт нь орхиод гэртээ харьснаас цаг орчмын хойно ах маань амьсгал хураасан гэнэ. Түүнийг тураалаар эцэслэсэн хэмээн тодорхойлсон байж билээ."*

Дээр өгүүлсэн Даваадэлгэр хэмээх эр бол энгийн ялтан, давтан гэмт хэрэг үйлдсэн хүн байжээ. 1994 оны гуравдугаар сарын 25-ны өдөр шоронгийн эмнэлэгт нас барахдаа 36 настай байв.

## МОНГОЛ УЛС

### ХОРИГДЛУУД ӨЛБӨРЧ ҮХЭЖ БАЙНА

#### Удиртгал

Монголд шоронгийн хоригдлууд өлбөрч үхэж байна. Эрх баригчдын зүгээс огт хайхрамжгүй ханддаг, заримдаа санаатайгаар хэрцгий харьцдаг нь үүний шалтгаан болдог ажээ. Өнөөгийн нөхцөлд Монголын шоронд аливаа ял эдлэх нь цаазлуулах ял авсантай бараг адилхан байна. (Монголын эрх баригчид ч хүлээн зөвшөөрсөн) уг асуудлын учир шалтгааныг анхааралтай авч үзээд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө өгч байгаа юм.

Түүнээс гадна, Монголд цаазаар хороох ялыг хэрэглэсээр байгаа тухай энэхүү тайланд дэлгэрэнгүй дурьдах болно. Хоригдлыг цаазлах ялаас амь хэлтрүүлээд хугацаагүй хорих тусгай салбарт ганцааранг хорьдог нь хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа буюу шийтгэлтэй чанар нэг гэж болмоор бөгөөд энэ явдлыг энд шүүмжилж байна.

#### Шоронд хоригдлууд өлсч буй асуудлын хоёр тал

Өлсгөлөн бол Монголын хорих байгууллагад гарч буй цоо шинэ асуудал биш юм. Энэ тухай Монголын хэвлэл мэдээлэлд цаад зах нь 1992 оноос эхлэн мэдээлсээр байна. Уг асуудал нь хоёр талтай. Үүнд:

- Мөнгө дутагдалтайгаас болж хорих ангиуд ял эдэлж буй хоригдлуудыг зохих хоол хүнсээр хангаж чаддаггүй;
- Урьдчилан хорих үеэр албадан хэрэг хүлээлгэхийн тулд санаатайгаар өлсгөдөг ба энэ бол хэрдгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа мөн бөгөөд эрүү шүүлт гэхэд ч болох юм.

Энэ хоёр тал хоорондоо холбоотой. Нэгэнт урьдчилан хорих үеэр санаатайгаар өлсгөдөг учир хорих ангиудын хайхрамжгүй байдал нь шүүхийн тогтоолоор ял эдлэхээр очиж байгаа хүмүүсийг үхэл рүү аваачихтай адил ажээ. Урьдчилан хоригдох үедээ тэжээлийн айхтар дутагдалд орсон хүмүүс хорих ангиудад ирдэг тухай Олон Улсын Амнестид албаны болон албаны бус эх сурвалжаас мэдэгдсэн билээ. Зарим хүн засал авч чадалгүй амь аллах нь ч бий ажээ.

*Хорих байгууллагад хүнсний хангамж хүрэлцээгүй байдаг нь*

1993 оны намраас 1994 оны намар хүртэлх хугацаанд ерэн хоригдол шоронд нас баржээ. Энэ бол албаны тоо бүртгэлээс Олон Улсын Амнестид өгсөн хамгийн шинэ мэдээ юм. Тэдний дотроос өлсгөлөнгөөр нас барсан хүний тоо аль байгууллага мэдээлж буйгаас шалтгаалан 15-аас 30-ын хооронд хэлбэлзэх бөгөөд бусдыг нь өвчин, ажлын ослоор үхсэн гэжээ. Албаны хүмүүсийн өгсөн аль ч тоо нь хоригдлууд өлсгөлөнгөөр эцэслэж буй асуудлын цар хэмжээг нарийн тусгаж чадаагүй хэмээн Олон Улсын Амнести үзэж байна. Тэжээлийн дутагдал нь хүний дархлалын системийг нэрвэж, өвчин эсэргүүцэх чадварыг муутгадгийг санавал,

өвчнөөр эгэслэсэн гэж албан ёсоор тооцож буй олон хоригдлын үхэл өлсгөлөнгөөс дам шалтгаалсан байж магадгүй юм.

Хоолны хангамж хүрэлцээгүй байдаг асуудал бол "Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай" хуулийн "...бусад хоригдол хоол, хувцас, ор дэрний хэрэгсэл, амьдрах байрны эрчим хүч, дулааны зардлыг хөдөлмөрөөрөө хариуцна" (Зүйл 11.3) гэсэн заалтаас шууд үүдэн гарчээ. Өөрөөр хэлбэл, шоронгийн хоолны зардлыг улсын төсвөөс шууд гаргадаггүй, харин хоригдлууд хөдөлмөрийнхөө хөлсөөр хоол идэх тул ажиллах ёстой гэж уг хуульд шаарджээ. Зөвхөн насанд хүрээгүй болон тахир дутуу хоригдлол энэхүү шаардлагаас чөлөөтэй бөгөөд тэдний хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг ажээ.

---

## МОНГОЛЫН ШОРОНГИЙН ТОГТОЛЦОО

1994 оны 12 дугаар сарын байдлаар хорих ял эдэлж буй хүний тоо 5300 орчим байв.

Хоригдлууд жирийн, чанга, онцгой гэсэн гурван янзын дэглэмтэйгээр зохион байгуулсан хорих ангиудад (мөн засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага хамаарна) ял эдлэдэг. Шүүх яамны дэргэдэх Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтсийн удирдлага дор жирийн дэглэмтэй долоо, чанга дэглэмтэй дөрөв (Мааньт, Зүүнхараа, Багануур, Дарт), онцгой дэглэмтэй нэг (Авдарант), нийт 12 хорих анги байна. Түүнээс гадна, Монголын 21 аймгийн ихэнхэд нь жирийн дэглэмтэй хорих анги бий бөгөөд тэдгээрийг аймгийн захиргаа Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран хянадаг.

Эмэгтэйчүүдийн жирийн дэглэмтэй нэг хорих анги нийслэл хот Улаанбаатарын дүүрэг Баянзүрхэд байдаг. Насанд хүрээгүй эмэгтэй хоригдлыг бусад хоригдлоос тусад нь байлгадаг хэмээн албан ёсоор мэдэгддэг боловч хамтад нь хорьдог байна. Насанд хүрээгүй эрэгтэй хоригдлыг бас Улаанбаатарт байдаг тусгай хорих ангид байлгадаг. Хоёуланг Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтэс шууд захирдаг. 1995 оны 1 дүгээр сард Засгийн газрын төв хэвлэл "Ардын эрх" сонинд нийтлэсэн мэдээгээр бол насанд хүрээгүй 90 эрэгтэй, 7 эмэгтэй хоригдол ял эдэлж байгаа ажээ. Хорих анги бүр эмнэлэгтэй, мөн тухайн хорих ангийн эмнэлэгт эмчлэх аргагүй хүнд өвчтөнд зориулсан хорихын нэгдсэн эмнэлэг Улаанбаатарт (Ганц Худагийн шоронгийн дэргэд -доор бичсэнийг үз) байдаг.

Мөрдөн байцаагдаж, шүүн таслуулах үедээ цагдан хоригдож байгаа хүмүүсийг цагдаагийн байгууллага хариуцдаг. Тэднийг дүүргийн юмуу аймгийн цагдаагийн газар, мөн Улаанбаатар дахь Ганц Худагийн мөрдөн байцаах гянданд хорьдог ажээ.

---

"Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай" хуулийн 11(3)-р зүйлийн заалт нь олон улсын хэм хэмжээг<sup>1</sup> зөрчсөн төдийгүй илт бүтэшгүй заалт байна. Энэхүү хуулийг дөнгөж 1994 оны эхээр баталж гаргасан атал хоригдлын хоолны хангамжийг түүний хөдөлмөрийн хөлстэй холбосон агуулга нь өмнөх хууль тогтоомжоос хэвээр үлджээ. Урьд бол хоригдлууд хорих ангийн дэргэдэх үйлдвэр, аж ахуйн газар ажилладаг байв. Тэр үед Монгол улс төлөвлөгөөт эдийн засагтай байсан тул хорих ангийн дэргэдэх аж ахуйн газруудад захиалсан бүтээгдэхүүний

норм нь улсын төвлөрсөн эдийн засгийн төлөвлөгөөнд багтдаг байлаа. Зах зээлийн эдийн засгийн шинэ нөхцөлд хорих ангийн дэргэдэх аж ахуйн газрууд тэр бүр тогтнох найдваргүй, хариуцсан эрх баригчид зарим хоригдолд ажил олох гэж зүдэрч байгаа ажээ. Хуульд хоригдлын хоолыг хөдөлмөртэй нь холбосныг салангид болгож, хоригдлын хөдөлмөрийн нэмэр хандивыг үл харгалзан тэжээх үүргийг улсад хариуцуулах гэсэн саналыг уг хуулийн төсөлд удаа дараа оруулсан боловч үнэ өртөг ихтэй гэсэн шалтгаанаар Парламент хэрэгсээгүй байна. Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтэс санхүүгийн талаар туйлын гачигдалтай байгаа юм. 1995 онд улсын төсвөөс 500 сая төгрөг (250 000 ам. доллар) хуваарилсан нь хэрэгцээтэй мөнгөний дөнгөж тал хувьтай тэнцэх ажээ.

Ийм асуудал байгаа боловч хоригдлуудыг хүрэлцэхүйц хоол ундаар хангаж чаддаг хэмээн албаны хүмүүс хэлж байна. 1994 оны 12 дугаар сард Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтсийн дарга Олон Улсын Амнеститай ярилцахдаа хоригдлуудын хоолны ноогдлын журмын талаар тайлбарлаад тэр журмыг мөрдөж байна гэсэн юм. Тэгээд өөр өөр зэрэглэлийн хоригдолд өгдөг өдөр тутмын илчлэгийн хэмжээг нэрлэв.<sup>2</sup> Түүнчлэн журмын дагуу шоронгийн хоолонд<sup>3</sup> оруулдаг янз бүрийн хүнсийг нэрлэн тоочоод харин энэ жагсаалтад багтдаг хүнсний зүйлээс одоогоор уг хэлтсийн олж авч чадаагүй байгаа нь гагцхүү элсэн чихэр байна хэмээн тайлбарлав.

Гэтэл өлсгөлөнгөөр эцэслэсэн хүний одоо мэдэгдэж буй тоо хоолны хангамжийн талаар дээр өгүүлсэн зүйлийг нотлохгүй байгаагийн зэрэгцээ албаны бус хүмүүс үүнийг эрс няцааж, хоригдолд өгвөл зохих хамгийн бага хэмжээний ч хоол хуваарилж чадах баталгаа шоронгийн захиргаанд байхгүй хэмээн Олон Улсын Амнестид мэдэгдсэн юм. Эдгээр албаны бус эх сурвалжийн мэдээлснээр бол, шоронд зөвхөн адууны мах, цагаан будаа,



муу чанарын талх л олддог байна. Бага илчлэгтэй хоол нь, ялангуяа тэжээлийн тэнцвэрийн алдагдалтай хослобол тэжээлийн хямралд орж, дархлалын хариуцах чадвар буурч, өвчин халдварлах аюул ихээхэн нэмэгдэж болно. Хорих байгууллагад хоригдлууд ихэвчлэн өлсгөлөн ба тэжээлийн дутагдал хэмээгч гол хоёр хүчин зүйл дархлалын системийг нэрвэсний улмаас үүдсэн элдэв янзын өвчнөөр үхдэг гэж Олон Улсын Амнестид Монголын мэргэжлийн эмч нэг хүн хэлсэн билээ. Хорихын нэгдсэн эмнэлэгийн өвчтөнгүүдийн ихээхэн хувь нь гэнэт жин алдан тураалд орсон байдаг бөгөөд энэ бол дархлалын хариуцах чадвар буурсны дунд үүсдэг өвчний хавсарга шинж юм.

Албаны бус эх сурвалж болон Монголын хэвлэл мэдээлэлд гарсан баримт сэлт нь албаны хүмүүсийн хэлсэн зүйлийг огт нотлохгүй байна. Харин өлсгөлөн хоригдлууд цөхрөнгөө барахдаа ямар байдалд орцгийг өгүүлжээ. Урьд хоригдож байсан нэг хүний өөрт нь ярьсныг гэрийнх нь нэг хүн даруй Олон Улсын Амнестид дэлгэрэнгүй мэдээлсэн нэгэн явдлыг дурьдваас, Мааньтын хоригдлууд хорих ангийнх нь хавиар тэнэж явсан нэг муурыг барьж аваад түүхийгээр нь идэхэд хүрчээ. Засгийн газрын сонин "Ардын Эрх" 1994 оны 12 дугаар сарын 21-ний дугаартаа гаргасан шоронгийн нөхцөлийн талаархи нэг нийтлэлдээ хоригдлууд өлсөхдөө хорих ангийн хог хаягдлаас төмсний хальс түүж иддэг байсан тухай Мааньтад хоригдож байсан өөр нэг хүний ярьснаас иш татжээ. Түүнчлэн тус нийтлэлд Багануурт хоригдлууд нэг гөлөг алан чанаж идсэн тухай дурьдсан байна.

Хангалтгүй ариун цэвэр, эмнэлгийн тусламжийн тухай бусад асуудал

Шоронгийн ахуй нөхцөлийн ерөнхий түвшин хэтэрхий муу гэдгийг албаны хүмүүс Олон Улсын Амнестид нууцгүй хэлсэн юм. Хүн нь ихэдсэн, хувцас, эм тариа хүрэлцээгүй, ариун цэвэр муу ажээ. Энэ нь хорих ангиудын ахуй нөхцөлийн талаар албаны бус сурвалжаас өгсөн мэдээлэлтэй тохирч байна. Олон улсын шалгуурт<sup>4</sup> тэнцээгүй ийм нөхцөл хоригдлуудыг өвчнөөр үхэхэд нэрмээс болдог биз ээ.

Журам ёсоор бол хоригдлууд долоо хоногт нэг удаа усанд орох боломжтой байх ёстой ажээ. Гэтэл Олон Улсын Амнестид мэдээлснээр бол үнэн хэрэг дээрээ хорих ангиудад халуун усны шүршүүртэй өрөө байлаа ч гэсэн голдуу ажилдаггүй учраас хоригдлууд усанд олигтой сайн орж чаддаггүй байна. Түүнээс гадна санхүүгийн гачигдлын улмаас долоо хоногт нэг удаа хувцас солих журам хэрэгжиж чаддаггүй ажээ (хувцасны зардлыг хоолныхтой нэгэн адил хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутган төлдөг). Үүний уршгаар арьсны өвчин гардаг байна.

Түүнчлэн олонхи хорих ангид амны цэвэр ус хүрэлцдэггүй тухай гомдлыг Олон Улсын Амнести сонссон. Зарим нь хоолойгоос ч, худгаас ч шууд авч чаддаггүй учраас амны усыг усны тэргээр зөөх болдог. Үүнээс болж ялангуяа зуны цагт гэдэс гүйлгэх зэрэг эрүүл мэндийн холбогдолтой асуудал гардаг байна.

Хорих ангийн эмнэлгүүд эм хэрэгслийн хангамж муутай байдгийг Олон Улсын Амнестид мэдээлсэн юм. Эдгээрийг Эрүүл Мэндийн яамнаас худалдаж авах ёстой бөгөөд Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтэст улсаас өгдөг төсөв хэрэгцээтэй бүх зүйлийг авах зардалд хүрэлцдэггүй.

*Урьдчилан хорих газар санаатайгаар өлсгөдөг нь*

Хорих ангиудад нас барсан хүмүүсийн дийлэнх нь шүүхээр таслуулахын өмнө хоригдож байхдаа хэдийн өлбөрсөн байдгийг 1994 оны 12 дугаар сард Монголын нэг эмч Олон Улсын Амнестид хэлсэн билээ. Хорих ангид олон хүн хэдийн өвдсөн юмуу, тэжээлийн дутагдалд орчихсон ирдэг ба зохих хэмжээний хоол унд өгөөд ч нэмэргүй, нэгэнт засал авахаас өнгөрсөн байдаг нь олонтаа гэдгийг Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтсийн дарга ч бас онцлон тэмдэглэв. Хагас дутуу хоол өгдөг, мөн гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдэд албадан хэрэг хүлээлгэхийн тулд зориуд хоол өгдөггүй явдал бол хоригдлууд мөрдөн байцаагдаж, шүүн таслуулахаар цагдан хоригдож байх үедээ өлбөрсөн байдгийн шалтгаан юм гэжээ. Урьдчилан хоригдож буй хоригдлуудыг санаатайгаар өлсгөдөг явдлыг дээд албаны хариуцсан эрх баригчид зүгээр өнгөрөөдөггүй гэдгийг энд цохон тэмдэглэх нь чухал юм. Тийм явдал гардаг гэсэн баримтыг Шүүх яамны тэргүүн дэд сайд Олон Улсын Амнеститай ярихдаа шууд хүлээсэн боловч тэр нь хувь хүний буруу үйлдлийн уршиг байдаг бөгөөд илэрсэн цагт нь шийтгэл хүлээлгэдэг хэмээн тайлбарласан билээ.

Хүний эрхийн төлөө тэмцэгч нэг монгол хүн уг явдлыг судлан сурвалжлаад, байцаалтын үеэр хэрэг хүлээгээгүй хоригдлыг өрөөнд нь буцаагаад дараачийн байцаалт хүртэл хоолны ноогдлыг нь хэдэн өдрөөр багасгадаг, эсвэл бүрмөсөн хасдаг тухай Олон Улсын Амнестид мэдэгдэв. Тэгээд байцаалтын хоорондох хоёр долоо хоногийн турш нэг хүнд гол зогсох төдий хоол өгч байсан нэг явдлыг иш татжээ. Англи хэлээр гардаг "Mongol Messenger" сонины 1994 оны 12 дугаар сарын дугаарт иш татсан Улсын Прокурорын байгууллагаас явуулсан судалгаанд өнгөрсөн 4 дүгээр сараас хойш Ганц Худагийн шоронд хоригдож байсан 700 хоригдлоос 247

нь тэжээлийн дугаглалд орсон бөгөөд тэднээс 7 нь нас барсныг тэмдэглэжээ.

### *Зохисгүй харьцааны талаар гомдол гаргах*

Дээр өгүүлсэн асуудлуудыг болон баривчлах үеэрээ цагдаа нар, эсвэл байцаалтын үеэр мөрдөн байцаагч нар зодож занчсан ба зохисгүй харьцсан гэх бусад явдлын талаар Монголын хэвлэл мэдээлэлд өргөнөөр хэлэлцэж байгаа хэдий боловч хувь хүмүүс эрх мэдэл бүхий этгээдийн эсрэг албан ёсоор гомдол гаргахаас ерөнхийдөө дургүйцдэг тухай Олон Улсын Амнестид албаны ба албаны бус эх сурвалж хоёул мэдэгдсэн билээ. Албан тушаалаа урвуулан ашигласан төрийн эрх баригчдын эсрэг прокурор болон шүүхэд гомдол гарган заалдах ба байцаан шийтгэх ажиллагааны үйлдэл санаачлах бололцоо нээлттэй гэдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй, эсвэл итгэдэггүй гэж 1994 оны 12 дугаар сард Шүүх яамны тэргүүн дэд сайд Олон Улсын Амнестид ярьсан билээ.

Гэтэл олон улсын хуулийн баримт бичгүүдэд хүний эрхийг зөрчсөн тохиолдолд хууль зүйн хамгаалалт авах хүн бүрийн, түүний дотор хорионд байгаа этгээдийн эрхийг хүндэтгэх явдлыг баталгаажуулсан төдийгүй тэр эрхээ хэрхэн эдлэбэл зохихыг хүн бүрд таниулж, тэгснээрээ уг эрхийг үр ашигтай хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулахыг эрх баригчдад үүрэг болгосон байдаг билээ.<sup>5</sup>

## Хоригдлуудыг өлсгөдөг ба зүй бус харьцдаг явдалтай тэмцэх талаар Олон Улсын Амнестигаас зөвлөгөө болгох нь

Хорих ангиудад хүмүүс өлсч байгаа асуудлыг шийдвэрлэх гэж Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтэс нилээд чармайсныг Олон Улсын Амнести хүлээн зөвшөөрч байна. Тус хэлтэс нь энэрэнгүй тусламжийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үр тариа ургуулах, мал өсгөх, худаг ухах зэрэг өөртөө туслах ажил явуулж байна. Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат 1995 оны 1 дүгээр сарын эцсээр НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Боутрос Боутрос Галид өргөсөн тайландаа Монгол улс нь шорон гяндан, хорих ангиудын ахуй нөхцөлийг сайжруулахад зориулан "санхүүгийн болон бусад тусламжийг НҮБ-аас эрэлхийлж байна хэмээн мэдэгджээ. Чингэвч, хоригдлуудад орлогын эх үүсвэр болдог ажил олдохгүй байгаа нь хэргийн гол учир мөн гэж Монголын эрх баригчид үзсээр байгаа явдалд Олон Улсын Амнести харамсаж байна. Иймээс Олон Улсын Амнестигаас доорхи зөвлөгөөг өгч байна:

- "Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай" хуульд засвар хийж, хоригдлын хөдөлмөрийг хоол ба бусад үйлчилгээгээр хангах явдалтай шууд холбодгийг зааглабал зохино. Монгол улс 1974 онд гарын үсэг зурсан "Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын" (ИУТЭОУП) 6 дугаар зүйлээр баталгаажуулсан хоригдол хүний амьд явах эрхийг хамгаалах олон улсын хэм хэмжээг биелүүлэх үүрэгтэй гэдгээ Монголын эрх баригчид хүлээн зөвшөөрөх ёстой. Тэгэхээр "Хэм хэмжээний Наад захын дүрэм", "Аливаа төрлийн хорио, шоронд байгаа хүн бүрийг хамгаалах НҮБ-ын Нэгдсэн зарчмаар (Нэгдсэн зарчим) хүлээсэн

үүргээ хэрэгжүүлж, бүх хоригдлыг зохих хоол, эмнэлгийн тусламжаар хангах ёстой.

Нэмж хэлэхэд, Олон Улсын Амнести нь энэхүү тайлангаар дамжуулан энэрэнгүй тусламжийн ба шоронг өөрчлөх зорилготой байгууллагуудын сонирхлыг уг асуудалд хандуулж, улмаар Монголын шоронд гарч буй өлсгөлөнгийн болон муу ахуй нөхцөлийн бусад асуудлыг нэг тийш болгоход тийм байгууллагууд Монголын эрх баригчидтай хамтран ажиллах явдлыг хөхиүлэн дэмжихийг эрмэлзэж байгаа юм.

Шүүн таслах ажиллагааны өмнө урьдчилан хорих үеэр санаатайгаар өлсгөх явдалтай албан ёсоор эвлэрдэггүй, харин тэр нь хувь хүний зохисгүй үйлдлийн уршиг байдаг хэмээн Шүүх яамны тэргүүн дэд сайдын нотлон хэлснийг Олон Улсын Амнести хүлээн авч байна. Чингэвч Олон Улсын Амнести нь цагдан хоригдсон этгээдтэй тиймэрхүү байдлаар зохисгүй харьцах явдлаас сэрэмжлэхийн тулд олон улсын хэм хэмжээнд<sup>6</sup> нийцүүлэн дараахь зүйлийг хийхийг Монголын эрх баригчдад зөвлөж байна. Үүнд:

- Цагдан хоригдсон хүн бүрд эрхийг нь, түүний дотор зохисгүй харьцааны талаар гомдол гаргах эрхтэй болохыг таниулах ("Хэм хэмжээний Наад захын дүрмийн" 35-р дүрэм; "Хэм хэмжээний Наад захын дүрмийг үр ашигтай хэрэгжүүлэх журмын" 4-р журам);

- Гомдлыг хянан шийдвэрлэх үр ашигтай, чигч журмыг шийдвэр биелүүлэх эрхийн чадвартайгаар бий болгох ("Хэм хэмжээний Наад захын дүрмийн" 36-р дүрэм; "Нэгдсэн Зарчмын" 33-р зарчим);
- Аливаа хорих газрыг шалгах хараат бус шалгалтын үр нөлөөтэй систем бий болгох ("Хэм хэмжээний Наад захын дүрмийн" 55-р дүрэм);
- "Эрүү шүүлт ба бусад төрлийн хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа ба шийтгэлийн эсрэг НҮБ-ын гэрээнд" гарын үсэг зурах ба нэгдэх явдлыг эн тэргүүний зүйл болгон авч үзэх;
- Зохисгүй харьцсан буруутай этгээдийг шүүхэд өгөх ("Хүний Эрхийн хорооны Ерөнхий Тайлбар", 20-р тайлбар, 13-р хэсэг);
- Урьд 1992 онд Олон Улсын Амнести нь *"Монгол Улс. Хууль тогтоомжийн өөрчлөлт хийж байгаа нь"* (Индекс: ASA 92.01.30) хэмээх тайландаа зөвлөсөнчлөн засаг төрийн албан хаагчдын талаар иргэдээс ирүүлсэн гомдлыг хянан үздэг түшмэлийн алба бий болгох заалтыг Монголын Үндсэн Хуульд оруулах. Ийм түшмэл бол ер нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн, эрх мэдлээ урвуулан ашигласан, захиргааны албан хаагчдаас иргэдтэй хууль бус, дур зоргоороо, шударга бус харьцсан гэгдсэн болон тэр нь нотлогдсон аливаа тохиолдлыг хянан байцаах, мөн тэдгээр зөрчил, эрх мэдлээ хэтрүүлсэн ба шударга бус харьцааны улмаас хохирсон этгээдийг хохиролгүй болгоход туслах үүрэгтэй юм. Цагданд болон шоронд хоригдсон этгээдийг хамгаалах явдлыг

баталгаажуулахын тулд гомдол хянах түшмэл аль ч хорих газарт урьдаас мэдэгдэлгүйгээр хэдийд ч нэвтрэн ордог эрх эдлэх ёстой. Түүнчлэн аливаа зөрчлөөс учруулсан хохирлыг арилгах, засч залруулах ба зөрчлийг таслан зогсоохыг шаардаж, зохих арга хэмжээ авах эрх эдлэх бөгөөд үүнд нь бүрэн эрхтэй шүүхээр хэргийг хянан хэлэлцүүлэхээр өгөх, хуульд юмуу, сахиж буй журамд өөрчлөлт оруулах талаар зохих эрх баригчдад санал, зөвлөгөө өгөх эрх багтана.

## ЦААЗААР ХОРООХ ШҮҮХИЙН ЯЛЫГ МОНГОЛД ХЭРЭГЛЭЖ БАЙГАА НЬ

Монгол улс нь цаазаар хороох ялыг хуульдаа хэвээр байлгасаар бөгөөд цаазаар хороох шийдвэр байнга гаргаж, түүнийгээ хэрэгжүүлсээр байна. Саяхан цаазаар авах ял оноох онц хүнд гэмт хэрэгт багтдаг хэргийн тоог цөөрүүлсэн, мөн ерөнхийлөгч Очирбат цаазаар хороох ялыг цуцлах асуудлыг хэлэлцэж байгаа тухай мэдэгдсэн наашгай алхмууд нь уг ялаар шийтгэх явдал нэмэгдэж буйг харуулсан статистикийн мэдээний дэргэд шалхгүй зүйл ажээ. Хуучин ЗХУ-аас их хэмжээгээр өгдөг байсан бэлэг, мөнгөн тусламж 1990-1991 онд зогссон, түүнчлэн бараг 70 жилийн турш бүх хүнийг ажлаар хангадаг, нийгмийн даатгалыг улс гаргадаг систем бүхий төлөвлөгөөт эдийн засагтай, захирдаг ганц намтай коммунист улс байсан Монгол орон зах зээлийн эдийн засгийн нээлттэй нийгэмд шилжих хэцүү бэрх замд орсон нь Монголын эдийн засгийг огцом доройтуулж, эдийн засаг, нийгмийн хямралыг түргэсгэсний улмаас гэмт хэрэг жилд 13 - 15 хувиар өссөн нь цаазаар хороох ялын тоог нэмэхэд хүргэжээ.



*Цаазаар хороох ял авах онц хүнд гэмт хэрэг ба уг ялыг цуцлах алсын төлөв*

1993 оны 7 дугаар сараас хүчин төгөлдөр болгосон Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж, онц хүнд гэмт хэрэгт тооцох 8 төрлийн хэрэг байсныг 5 болгон цөөрүүлжээ. Үүнд:

- Улс төрийн зорилгоор аллага хийх (62-р зүйл)
- Улс төрийн зорилгоор гадаад улсын төлөөлөгчийн эсрэг аллага хийх (63-р зүйл)
- Хорлон сүйтгэх (64-р зүйл)
- Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (86-р зүйл)
- Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг хүчиндэх (112-р зүйл, 3-р хэсэг)

Эдгээр таван төрлийн онц хүнд гэмт хэрэгт цаазаар хороох ялыг зайлшгүй шийтгэл болгон өгдөггүй, харин засаг төрийн ажилтнуудын хэлснээр бол үнэндээ зөвхөн сүүлийн хоёр хэрэгт буюу хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алсан ба хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг хүчиндсэн хэрэгт цаазаар хороох ял оноодог байна. Үнэндээ сүүлийн жилүүдэд ер гараагүй боловч олон түмний санаа бодолд нийцүүлэхийн тулд парламентад оруулсан анхны саналаас өөрөөр шийдэж, дээрх таван төрлийн гэмт хэргийн эхний гуравт цаазаар хороох ял шийтгэх заалтыг хэвээр үлдээсэн юм гэж Шүүх яамны тэргүүн дэд сайд Олон Улсын Амнестид хэлсэн юм.

Монголын ард түмэн, түүний удирдагчид хүний эрхийн төлөө, гэмт хэргийг шийдвэрлэх зөв зүйтэй хариу олохын төлөө зүтгэж, цаашдаа цаазаар хороох ялыг төгсгөл болгохоор шийднэ гэдэгт Олон Улсын Амнести итгэж буйгаа мэдэгдье.

### *Яллах, заалдах, өршөөх*

Олон Улсын Амнестид өгсөн албан ёсны статистикийн хамгийн сүүлийн мэдээгээр бол, 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 1 хүртэлх хугацаанд цаазаар авах ялын тогтоол 26 удаа гаргасан байна. Уг хугацаанд цаазлах ялын чухам хэдийг нь гүйцэтгэсэн талаар нарийн мэдээ олдоогүй, пүүхээр тогтоосон нийт цаазлах ялын бараг хагасыг нь сүүлдээ гүйцэтгэдэг гэж албаны хүмүүс Олон Улсын Амнестид хэлсэн юм. Олдож буй албан ёсны хамгийн сүүлийн тоо баримтаар бол 1992 онд цаазлуулах ял шийтгүүлсэн 22 хүнээс 11 хүнийг хороожээ. 1991 онд бол цаазаар хороох 19 ялаас 10 ялыг нь гүйцэтгэсэн, харин 1990 онд зөвхөн 5 ял гүйцэтгэсэн байв. Цаазаар хороох ялыг буудаж гүйцэтгэдэг байна.

Цаазаар хороох ялыг анхны шатанд 21 аймаг, Улаанбаатар хотын шүүхээр таслан шийдвэрлэж онооно. Эмэгтэйчүүд, 18 насанд хүрээгүй, эсвэл 60 буюу 60-аас дээш насны хүнд цаазаар хороох ял оноодоггүй. Цаазлах ялаар шийтгүүлсэн хүн ялын тогтоол ба ялыг эсэргүүцэн Дээд шүүхэд давж заалдах эрх эдлэдэг. 1994 оны 12 дугаар сард Дээд шүүхийн ерөнхий шүүгч Олон Улсын Амнестид тайлбарлан өгүүлснээр бол, 1993 онд батласан шинэ журам ёсоор аймаг, хотын шүүхийн шийдвэрийг өөрчлөх эрх бүхий Дээд шүүхийн гурван шүүгчээс бүрдсэн зөвлөл нь аливаа нэг заалдсан өргөдлийг хянан хэлэлцдэг. Харин тэд тухайн ялыг

Үндсэндээ парламентын ихэнх гишүүн уг ялыг цуцлах саналыг дэмжихгүй байгаа учраас Үндсэн Хуульд засвар оруулж юмуу, Эрүүгийн хуульд дахин засвар оруулснаар цаазлах ялыг бүрмөсөн цуцлана гэдэг бол ойрын ирээдүйд бүтэшгүй зүйл гэж энэ сэдвээр 1994 оны 12 дугаар сард Олон Улсын Амнестигаас Монголд очсон төлөөлөгчтэй ярилцсан хүмүүс үзэж байв. Олон нийт бол цаазаар хороох ялыг хэвээр хадгалах талд тууштай зогсч байна. 1993 онд Эрүүгийн хуульд оруулах өөрчлөлт, засварыг хэлэлцэж байх үеэр парламентын дэргэдэх Хүний эрхийн дэд хороо цаазаар хороох ялыг бүрмөсөн цуцлах тухай санал оруулсныг парламент хэрэгссэнгүй. Хэдий тийм боловч 1995 оны 1 дүгээр сарын эцсээр НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргад өргөсөн бичигтээ ерөнхийлөгч Очирбат цаазаар хороох ялыг цуцлах тохиромжтой нөхцөл хараахан бүрдээгүй байна, харин үүнийг Эрүүгийн шинэ хууль боловсруулахаар одоо хийж буй ажлын хүрээнд авч үзнэ хэмээн мэдэгджээ.

Гэмт хэрэг ихсэх үед цаазаар авах ял гэмт хэргийг таслан зогсооход тустай гэж хүмүүс итгэдэг учраас цаазлах ялыг олон нийтээр голдуу дэмждэг. Олон Улсын Амнести нь Монголын удирдлага, парламентын гишүүд, хэвлэл мэдээллийнхэнтэй уулзаж ярилцах бүрдээ үүний худал болохыг, тухайлбал, цаазлах ял нь бусад төрлийн шийтгэлээс илүүгээр гэмт хэргээс сэргийлдэгийг батлах нотолгоо байхгүй гэдгийг үргэлж анхааруулж байлаа. Аль нэг засгийн газар хууль, журам албадан хэрэгжүүлэх явцдаа хүний эрх зөрчсөн үедээ хүмүүст буруу ойлголт өгдөг гэж Олон Улсын Амнести үздэг. Цаазаар хороох ял бол хүний амьд явах эрхийг зөрчсөн, туйлын хэрцгий, хүнлэг бус, доромжилсон шийтгэл мөн гэж Олон Улсын Амнести үзэж байна.

өөрчлөхгүй хэвээр үлдээхээр шийдвэл Дээд шүүх тус зөвлөлийг бүрдүүлсэн 3 шүүгчийг үл оролцуулан бүрэн бүрэлдэхүүнээрээ (нийт 17 шүүгчтэй) хуралдан дахин хянаж үзээд өөрчилж болно.

Нэмж хэлэхэд, Дээд шүүхийн бүх шүүгч нь шүүхийн анхны шийдвэрийн талаар аль нэг талын гаргасан гомдлыг үндэслэн анхан шатны шүүхээр хэлэлцсэн ямар ч хэргийг, түүний дотор онц хүнд хэргийг шүүхээр дахин хянуулахаар өгөхийг тушаах эрх эдлэдэг.

Шүүхийн нийт гишүүдийн гуравны нэг хувь нь дахин хэлэлцэх нь зүйтэй гэж үзээгүй бол тухайн хэргийг дахин хянаад гаргасан Дээд шүүхийн тогтоол эцсийн шийдвэр болдог. Шүүгчдийн гуравны хоёр хувь нь зүйтэй гэж үзвэл Дээд шүүхийн анхны дүгнэлтийг өөрчилж болно.

Хэрэв Дээд шүүхэд давж заалдаад дахин хянах ажиллагаа дуусч, цаазаар хороох ялыг өөрчлөлгүй хэвээр үлдээвэл ял хэлтрүүлэхийг хүссэн өргөдөл ерөнхийлөгчид гаргаж болно. Эрүүгийн хуульд оруулсан засварын ёсоор бол 1993 оны 7 дугаар сараас эхлэн улсын ерөнхийлөгч нь цаазаар хороох ялаар шийтгэгдэх гэмт хэрэгтэнд өршөөл үзүүлэхдээ цаазлах ялыг "хугацаагүй" хорих ялаар сольж болох эрхтэй ажээ. Цаазаар авах ялыг хөнгөтгөхдөө шүүхээс өгч болох хорих хугацааны дээд хэмжээнд нийцүүлэхийн тулд "хугацаагүй" хорих ялаар биш, харин дээд хугацаа болох 25 жил хорих ялаар солих эрхийг ерөнхийлөгчид олгохын тулд засгийн газар Эрүүгийн хуульд нэмэлт засвар оруулах санал гаргасан тухай Олон Улсын Амнестид мэдээлсэн юм.

## Цаазаар хороох ялын талаар Олон Улсын Амнестигаас зөвлөх нь

Олон Улсын Амнести нь цаазаар хороох ял гүйцэтгэх явдлыг зогсоох, мөн Үндсэн Хуульдаа өөрчлөлт оруулж, эсвэл Эрүүгийн хуулиас цаазаар авах ялын заалтыг хасан цаазаар хороох ялыг цуцлахыг Монголын эрх баригчдаас хүсч байна. Монгол улс цаазаар хороох ялыг хүчингүй болгох санаатай боловч харахан бэлэн биш байна хэмээн ерөнхийлөгч Очирбат саяхан мэдэгдсэнийг тэмдэглэхийн хамт Олон Улсын Амнести нь ядахнаа дараахь зүйлсийг хэрэгжүүлэхийг Монголын эрх баригчдаас хүсч байна. Үүнд:

- Цаазаар хороох асуудал эрхэлсэн албаны комисс байгуулах. Бусад орны туршилагаас үзвэл, цаазаар хороох ялыг цуцлах шийд даруй гаргах явдал бэрхшээлтэй оронд лавлах комисс байгуулах нь ямар нэгэн шийдвэрийн үндэслэл болж чадах баримт сэлт олж авахад тустай арга байж магадгүй. Ийм комисс нь цаазаар хороох ялын асуудлыг түүнийг үргэлж тойрч байдаг улс төрийн ба сэтгэлийн хөөрлийн уур амьсгалаас зааглан холдуулахад ашигтай болно. Комиссын олсон баримтууд нь албан тушаалтан, хууль тогтоогчид ба олон түмнийг тухайн асуудлын талаар шийдвэр гаргахад удирдлага болгох үнэн зөв мэдээллээр хангаж чадах юм.
- Цаазаар хороох ялын асуудал эрхэлсэн албаны комиссыг ажлын үр дүнг гарах хүртэл цаазаар авах ялыг хойшлуулах.

## АМЬ ӨРШӨӨХ НЬ ЧУХАМДАА НАСАН ТУРШ НЬ ГАНЦААРАНГ ХОРЬЖ МАГАДГҮЙ ГЭСЭН ҮГ БОЛОХ НЬ

Шүүх яамны дэргэдэх Засн Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтсийн даргын хэлснээр бол, ерөнхийлөгчийн өршөөлөөр цаазаар хороох ялыг нь хөнгөтгөн хугацаагүй хорих ял авсан хоригдлыг Авдарант дахь тусгай дэглэмтэй хорих ангийн "тусгай салбарт" ял эдлүүлдэг ажээ. "Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай" хуульд тодорхой заасанчлан ийм ялаар шийтгүүлсэн хоригдлыг эхний 5 жилд нь чанга дэглэмтэй гяндангийн нөхцөлөөр өдөрт зөвхөн нэг цаг салхинд гаргаж, жилд нэг удаа гэрийнхэнтэйгээ түр уулзахыг зөвшөөрч, хоёр сард нэг удаа захидал явуулах эрх олгож тусгай тасалгаанд орь ганцааранг хорьдог. Үлдэх хугацаанд нь хүнтэй уулзах, захидал явуулах, авах эрхийг нь нэмдэг ажээ.

Хугацаагүй хорих ял эдэлж байгаа зөвхөн ганц хүн бий гэсэн бөгөөд тэр нь Баярхүүгийн Алтанхуяг гэдэг хүн болохыг Засан Хүмүүжүүлэх Хөдөлмөрийн хэлтсийн дарга Олон Улсын Амнестиц хэлсэн юм. Энэ хоригдлын талаар өөр мэдээ олдожгүй байна.

Хугацаагүй ял эдлэх хоригдлуудыг байлгадаг ганцаарчлан хорих дэглэмийн мөн чанарыг нарийн тодорхойлохыг Олон Улсын Амнести Монголын эрх баригчдаас хүсч байна. Урт хугацаагаар тусгаарлах нь хоригдлын бие бялдар, оюун санаанд ноцтой нөлөөлж болдгийг манай байгууллага ажигласан бөгөөд үүнийг хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа ба шийтгэл мөн гэхэд болно. Бусад оронд урт хугацаагаар орь ганцаар хоригдсон хоригдлууд сэтгэлээр унах, бодож санах чадвар доройтох, нойр алдах, толгой өвдөж, эргэх, цусны даралт багасах, цусны

эргэлт, хоолны шингэлц муудах зэргээр санаа сэтгэл нь ч, бие бялдар нь ч хямардаг байна.

Хүнийг урт хугацаагаар ганцаарчлан хорьж сэтгэлийн зовлонд оруулбал олон улсын хууль зөрчиж байгаа хэрэг. Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцааг ИУТЭОУП-ын 7 дугаар зүйлд "хохирогчийг сэтгэлийн зовлонд оруулах аливаа үйлдлийг" хориглох (5-р хэсэг) ба "цагдан хоригдсон юмуу шоронд хоригдсон этгээдийг урт хугацаагаар ганцаарчлан хорих явдлыг 7 дугаад зүйлээр хориглосон үйлдлийн тоонд оруулж болох юм" (6-р хэсэг) хэмээснийг НҮБ-ын Хүний Эрхийн Хороо "Ерөнхий Тайлбарынхаа" 20(44) дугаар тайлбарт тодорхой тайлбарласан байдаг.

## ХАВСРАЛТ: ШОРОНГИЙН АХУЙ НӨХЦӨЛИЙН ТАЛААРХИ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

### *1. Хоолны хангамж*

"Захиргаанаас хоригдол бүрд ердийн цагт эрүүл мэнд, хүч тамирт нь шаардлагатай илчлэг чанарын, сайн бэлтгэсэн тэжээлийг хоол өгч байна"

*Хоригдолтой харьцах тухай НҮБ-ын хэм хэмжээний Наад захын дүрэм, 20(1)-р дүрэм.*

### *2. Ариун цэвэр, эмнэлгийн тусламж*

"Шаардлагад таарсан усны онгоц, шүршүүрээр тоноглох, тэгснээрээ тухайн цаг агаарт тохирсон хэмтэй усанд улирлын байдал, газар зүйн бүсийг харгалзан эрүүл ахуйн үүднээс усанд аль болох тогтмол, харин сэрүүн уур амьсгалтай газар дор хаяад долоо хоногт нэг удаа орох боломжийг хоригдол бүрд олгох ба тэднээс шаардана."

*Хоригдолтой харьцах тухай НҮБ-ын хэм хэмжээний Наад захын дүрэм, 13-р дүрэм.*

"Хоригдлууд хувийн ариун цэвэр сахих ёстой бөгөөд тэднийг ус болон эрүүл, цэвэрхэн явахад хэрэгтэй ариун цэврийн хэрэглэлээр хангана."

*Хоригдолтой харьцах тухай НҮБ-ын хэм хэмжээний Наад захын дүрэм, 15-р дүрэм.*



"Бүх хувцас цэвэрхэн, өмсөж болохуйц байна. Ариун цэвэр сахирын тулд дотуур хувцсыг аль болох тогтмол сольж, угаана."

*Хоригдолтой харьцах тухай НҮБ-ын хэм хэмжээний Наад захын дүрэм, 17(2)-р дүрэм.*

"Эмчлүүлэх шаардлагатай өвчтэй хоригдлыг эмчилгээний байгууллагад юмуу энгийн эмнэлэгт шилжүүлнэ. Эмнэлгийн багаж хэрэгслээр тоноглогдсон эмчилгээний байгууллагын тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, эм тариа нь өвчтэй хоригдлыг эмчлэн сувилахад зохимжтой байх, мөн зохих сургууль хийсэн ажилтнуудтай байна."

*Хоригдолтой харьцах тухай НҮБ-ын хэм хэмжээний Наад захын дүрэм, 22(2)-р дүрэм.*

"Цагданд юмуу шоронд хориглохоор хорих байранд юмуу, шоронд ирсэн хүнд эмнэлгийн зохих үзлэг аль болох шуурхай хийгээд хэрэгтэй бол эмнэлгийн тусламж үзүүлж эмчилнэ. Ийм эмнэлгийн тусламж, эмчилгээг үнэгүй хийнэ.

*"Аливаа төрлийн хорио, шоронд байгаа хүн бүрийг хамгаалах НҮБ-ын Нэгдсэн зарчим, 24-р зарчим.*

### *3. Гомдол гаргах*

"Энэхүү Пактад оролцогч улс бүр дараахь үүргийг хүлээнэ. Үүнд:

(а) Энд хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн ямар ч хүн, түүнийг нь албан ажлаа гүйцэтгэж байсан ажилтнууд зөрчсөн байлаа ч гэсэн үр ашигтай хууль зүйн хамгаалалт авах явдлыг баталгаажуулах;

(б) Хууль зүйн ийм хамгаалалт эрсэн хүнд тийм хамгаалалт эрэх үндэслэлээ мэргэжлийн шүүх, захиргаа, хуулийн байгууллага юмуу, улсын хуулийн тогтолцооны харьяанд байдаг эрх мэдэл бүхий бусад байгууллагаар шийдвэрлүүлэх, мөн хуулийн хамгаалалтын бололцоог хөгжүүлэх эрхийг нь баталгаажуулах;

(в) Ийм хууль зүйн хамгаалалт өгсөн үед зохих эрх мэдэл бүхий хүмүүс түүнийг хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах".

*Олон улсын Иргэний ба улс төрийн эрхийн пакт, 2(3)-р зүйл.*

"Баригдаж юмуу хоригдож эрх чөлөөгөө хасуулсан аливаа хүн тийн хоригдсон нь хууль ёсны дагуу эсэхийг шүүхээр нэн даруй тогтоолгох, хэрэв хууль бус бол цуцлах тушаал гаргуулахын тулд шүүхээр хэргээ хянуулан хэлэлцүүлэх эрх эдэлнэ."

*Олон улсын Иргэний ба улс төрийн эрхийн пакт, 9(4)-р зүйл.*

"Ял эдлэхээр ирсэн хоригдол бүрд түүнтэй адил төрлийн шийтгэлтэй хоригдолтой харьцахдаа баримтлах журам, тухайн байгууллагад мөрдөх сахилга, мэдээлэл эрх бэа гомдол гаргах зөвшөөрөгдсөн арга замын тухай, түүнчлэн эрх, үүргийнхээ аль алиныг ойлгох, хорих байгууллагын ахуй нөхцөлд биеэ дасгахад нь тус болох бусад чухал асуудлын талаархи мэдээллийг бичгээр өгнө."

*Хоригдолтой харьцах тухай НҮБ-ын хэм хэмжээний Наад захын дүрэм, 35(1)-р дүрэм.*

"Аливаа хоригдол ба цагдан хоригдсон хүнд ирсэн даруйд нь, мөн хоригдох хугацаанд нь "НҮБ-ын хэм хэмжээний Наад захын дүрмийг"

тухайн улсын хууль тогтоомж, бусад дүрэм журамд тусгаснаар нь тавилцуулан ойлгуулна."

*Хоригдолтой харьцах тухай хэм хэмжээний Наад захын дүрмийг үр ашигтай хэрэгжүүлэх журам, 4-р журам.*

"Хоригдол бүр байгууллагын захирал юмуу, түүнийг төлөөлсөн албаны хүнд ажлын аль ч өдөр өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

"Шоронгийн байцаагч ирж шалгах үеэр хүсэлт, гомдол гаргаж болно. Шоронгийн байцаагч юмуу байцаагч албаны бусад хүмүүстэй шоронгийн захирал ба орон тооны ажилтны оролцоогүйгээр ярилцах бололцоог хоригдолд олгоно.

"Хоригдол бүр зөвшөөрөгдсөн шугамаар шоронгийн төв захиргаа, шүүхийн байгууллага болон бусад эрх мэдэл бүхий байгууллагад өргөдөл, гомдол гаргаж болох бөгөөд түүнийх нь мөн чанарыг хянаж засалгүй хэвээр дамжуулна.

"Илт үндэслэлгүй хоосон л биш бол аливаа өргөдөл гомдлыг даруй барагдуулж хариуг шуурхай өгнө."

*Хоригдолтой харьцах тухай НҮБ-ын хэм хэмжээний Наад захын дүрэм, 36-р дүрэм.*

"Ялангуяа эрүүдэж шүүсэн юмуу хэрцгий, хүнлэг бус харьцан доромжилсон тохиолдолд цагдан хоригдсон ба шоронд хоригдсон этгээд өөрөө юмуу, өмгөөлөгч нь тухайн хорих газрын захиргааг хариуцсан эрх баригчдад юмуу, тэднээс дээш албан тушаалтанд, шаардлагатай бол хянан шалгах ба байцаан шийтгэх эрх мэдэл бүхий зохих эрх баригчдад гомдол гаргах эрх эдэлнэ."

*"Аливаа төрлийн хорио, шоронд байгаа хүн бүрийг хамгаалах НҮБ-ын Нэгдсэн зарчим, 33(1)-р зарчим.*

"Засаг төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас томилсон мэргэжлийн, туршлагатай байцаагч нар хорих газрууд ба тэдгээрийн алба, үйлчилгээг тогтмол шалгана. Тэдний даалгавар бол тухайн байгууллага ажлаа мөрдөж буй хууль, журмын дагуу явуулж байгаа эсэх, хорих ба засан хүмүүжүүлэх зорилгыг биелүүлж буй эсэхийг тогтоох явдал юм.

"Оролцогч орнууд тайлан гардуулахдаа эрүү шүүлт ба хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа ба шийтгэлд ял шийтгэл оногдуулна гэсэн заалт Эрүүгийн хуульдаа оруулсныг дурьдах ба тэгэхдээ тэдгээрийг энгийн албан хаагч юмуу, улсын нэрийн өмнөөс ажилласан өөр хүмүүс, эсвэл хувь хүн үйлдсэн тохиолдолд тийм ял шийтгэл оноох эсэхийг төдруулан заавал зохино. Хориглосон үйлдлийг хөхиүлэх, тушаан үйлдүүлэх, хүлцэн өнгөрөөх юмуу гардан үйлдэх зэргээр 7 дугаар зүйлийн (ОУИУТЭП; эрүү шүүлт, зохисгүй харьцааг хориглох тухай) заалтыг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх ёстой. Үүнээс уламжлаад сануулахад, тушаал дагахаас татгалзсан этгээдийг шийтгэх ба хариуд нь элдвээр харьцах ёсгүй."

*Хүний Эрхийн Хорооны Ерөнхий тайлбар, 20-р тайлбар, 13-р хэсэг.*

<sup>1</sup>Нэгдсэн Үндэстний Байгууллагаас (НҮБ) батласан "Хоригдолтой харьцах жам хэмжээний наад захын дүрмийн" 20(1)-р дүрэмд "Захиргаанаас хоригдол бүрд ердийн цагт эрүүл мэнд, хүч тамирт нь шаардлагатай илчлэг чанарын, сайн бэлтгэсэн тэжээллэг хоол өгч байна" хэмээжээ.

<sup>2</sup>Дээр хэлснээр хоригдлуудад өдөр тутам өгөх илчлэгийн хэмжээг дэглэм тус бүрд ийн тогтоожээ. Үүнд: тусгай хорих салбарт 2,900; онцгой дэглэмтэйд 3,400; чанга дэглэмтэйд 3,500; жирийн дэглэмтэйд 3,600. Зарим хоригдолд арай их хэмжээтэй өгдөг. Үүнд: насанд хүрээгүй хоригдолд 3,900; эмнэлэгийн өвчтөнд 3,900; сүрьеэтэй өвчтөнд 4,000. Зарим тохиолдолд илүү ноогдол олгодог. Үүнд: жирэмсэн эмэгтэй өдөр бүр 1,500-аар илүү илчлэг; шоронд ирэхдээ тэжээлийн дутагталтай байсан хүмүүс өдөр бүр 2,100 илчлэг нэмж өгдөг. Эдгээр ноогдол хоорондоо ихээхэн зөрүүтэй байгааг, түүнчлэн хөгжингүй

орнуудад бол насанд хүрсэн дундаж эр хүн өдөрт 2,700 орчим илчлэг хэрэглэдэг гэдгийг Олон Улсын Амнести тэмдэглэж байна.

<sup>3</sup> талх, тариа будаа, элсэн чихэр, мах, цай, давс, төмс, хүнсний ногоо, өөхөн тос, ургамлын тос, цагаан идээ, элэг.

<sup>4</sup>Хавсралтыг үз.

<sup>5</sup>Хавсралтыг үз.

<sup>6</sup>Олон улсын хэм хэмжээний татсан хамаарал бүхий ишгэлийн бүрэн эхийг Хавсралтанд оруулсан.